

“МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС” ХХК

Компанийн засаглалын үнэлгээний асуулга

Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана.

НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	<i>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>	Монгол Улсад хөрөнгө оруулалтын сан нь харьцангуй шинэ ойлголт бөгөөд сангуудын засаглалыг сайжруулах чиглэлд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой хэрэгжих журмыг боловсруулахаар судалгаа хийж байна.	Төлөөлөн удирдах зөвлөлийн журмыг ажлын хэсэг гарган боловсруулж байгаа.	2	80%
2	<i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</i>	Журмын төслийг боловсруулахаар хуулийн фирмтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд 2022.07.20-ны өдрийн байдлаар Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөөд байна.	Төлөөлөн удирдах зөвлөлийн сонгон шалгаруулалт, томилох асуудлыг тусгасан журмыг ажлын хэсэг гарган боловсруулж байгаа.	2	80%
3	<i>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.</i>	Мандал Ирээдүйн Өсөлт нь өөрийн ХОМК-ийнхоо https://mandalasset.mn/ цахим хуудсаар дамжуулан хөрөнгө оруулагч нартаа мэдээлэл хүргэдэг.	Хурлын ирцээс бусад мэдээллийг үйл ажиллагааны тайланд оруулдаг. Бид ТУЗ-ийнхаа гишүүдийн мэдээллийг цахим хуудсан даа байршуулахаар хөгжүүлэлт хийж эхлээд байна.	2	100%
4	<i>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</i>	<i>“Компани энэхүү кодексийн засаглалын зарчмуудыг бүрэн хэрэгжүүлэхийг эрмэлзэх ба компанийн үйл ажиллагааны онцлог, бүтэц, хэмжээ, хөгжлийн үе шат зэргээс шалтгаалан зарим нэг зүйлийг тухайлан хэрэгжүүлэх бололцоогүй, эсвэл зохион байгуулалтын илүү зохистой арга хэмжээг авч</i>	Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулаагүй. Хамтын ХОС нь ТУЗ-ийн 5 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн 9 гишүүнтэй ХК-тай адил олон хороодуудтай байх нь тохиромжгүй юм. Хамтын ХОС-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн нилээдгүй ачаалалтай байхаар байгаа тул Зохицуулагч байгууллагаас	2	80%

		хэрэгжүүлж болно” гэж зохицуулагч байгууллагаас зөвлөсний дагуу тохиромжтой хороодын бүтэц бүрэлдэхүүнийг батлахаар төлөвлөөд байгаа.	зөвлөмж авч хэрэгжүүлэхээр төслүүд нь хүлээгдэж байна.		
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийгшинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	“Мандал ирээдүйн өсөлт ХХХОС” ХХК нь 2021 он байгуулагдаж, туршлага, чадвартай ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулж, анх томилогдоход нь чиглүүлэх, сургалт уулзалтыг зохион байгуулан ажилласан. Мөн цаашид ТУЗ-ийн гишүүддээ ХОС-ийн талаар ойлголттой болох, мэдлэг ур чадвараа нэмэгдүүлэх сургалтын талаар судалгаа явуулж байна.	Шинэ ТУЗ-ийн гишүүнд байгууллагаа танилцуулах, дүрэм журмыг танилцуулдаг. Дотоод сургалт, Компанийн засаглалын гүнзгийрүүлсэн сургалт, Үнэт цаасны зах зээлийн бусад сургалтанд ТУЗ-ийн гишүүд бүрэн хамрагдсан.	2	100%
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Тийм. ТУЗ-ийн ажиллах журмын төсөлд энэ талаар тусгасан.	Журмын төслийг боловсруулахаар хуулийн фирмтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд 2022.07.20-ны өдрийн байдлаар Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөөд байна.	2	90%
ДҮН				12	88.33%
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ					
ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	ХОС нь хувьцаат компаниудаас ялгаатай зохицуулалттай бөгөөд “Мандал Ирээдүйн өсөлт хамтын ХОС” нь ТУЗ-ийн 5 гишүүнтэй бөгөөд 2 гишүүн нь хараат бус гишүүн байдаг.	Хамтын хос-ийн ТУЗ нь 5 буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон шаардлага хангасан хараат бус гишүүн байна.	2	100%
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Журмын төслийг боловсруулахаар хуулийн фирмтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд 2022.07.20-ны өдрийн байдлаар Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөөд байна.	Төлөөлөн удирдах зөвлөлийн сонгон шалгаруулалт, томилох асуудлыг тусгасан журмыг ажлын хэсэг гарган боловсруулж байгаа.	1	70%

9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Журмын төслийг боловсруулахаар хуулийн фирмтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд 2022.07.20-ны өдрийн байдлаар Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөөд байна.	Төлөөлөн удирдах зөвлөлийн сонгон шалгаруулалт, томилох асуудлыг тусгасан журмыг ажлын хэсэг гарган боловсруулж байгаа.	1	70%
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Журмын төслийг боловсруулахаар хуулийн фирмтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд 2022.07.20-ны өдрийн байдлаар Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөөд байна.	Төлөөлөн удирдах зөвлөлийн сонгон шалгаруулалт, томилох асуудлыг тусгасан журмыг ажлын хэсэг гарган боловсруулж байгаа.	1	70%
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Компани энэхүү кодексийн засаглалын зарчмуудыг бүрэн хэрэгжүүлэхийг эрмэлзэх ба компанийн үйл ажиллагааны онцлог, бүтэц, хэмжээ, хөгжлийн үе шат зэргээс шалтгаалан зарим нэг зүйлийг тухайлан хэрэгжүүлэх бололцоогүй, эсвэл зохион байгуулалтын илүү зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлж болно гэж зохицуулагч байгууллагаас зөвлөсний дагуу тохиромжтой хороодын бүтэц бүрэлдэхүүнийг батлахаар төлөвлөөд байгаа.	Хамтын ХОС нь ТУЗ-ийн 5 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн 9 гишүүнтэй ХК-тай адил олон хороодуудтай байх нь тохиромжгүй юм. Хамтын ХОС-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн нилээдгүй ачаалалтай байхаар байгаа тул Зохицуулагч байгууллагаас зөвлөмж авч хэрэгжүүлэхээр төслүүд нь хүлээгдэж байна.	2	80%
ДҮН				7	78.00%
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Журмын төслийг боловсруулахаар хуулийн фирмтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд 2022.07.20-ны өдрөөс хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөөд байна.	Төлөөлөн удирдах зөвлөлийн сонгон шалгаруулалт, томилох асуудлыг тусгасан журмыг ажлын хэсэг гарган боловсруулж байгаа.	2	80%

13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Журмын төслийг боловсруулахаар хуулийн фирмтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд 2022.07.20-ны өдрийн байдлаар Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөөд байна.	Журмыг баталснаар кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	2	80%
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Компанийн засаглалын кодекс нь 2022 оны I улиралд батлагдсантай холбоотойгоор Компанийн Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлж, 2022 оны хагас жилийн тайланд оруулахаар боловсруулж байна.		2	70%
ДҮН				6	76.67%
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Боловсруулсан	Боловсруулсан. Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулаагүй.	2	80%
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Тийм	Нэгж эрх эзэмшигчдийн хуралд оролцоно. Аудитын тайланг хурлын материалд оруулж танилцуулна.	2	100%
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны	Тийм	Дотоод аудитын талаарх мэдээллийг тухай бүрт мэдээллэж байхаар журамлаж байгаа.	2	90%

	<i>тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.</i>				
ДҮН				6	90.00%
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина					
18	<i>5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Боловсруулсан	Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг. ТУЗ хяналт тавидаг болох тогтоолцоог боловсруулж байгаа.	1	70%
19	<i>5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</i>	Боловсруулсан	эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг. ТУЗ хяналт тавидаг болох тогтоолцоог боловсруулж байгаа.	1	70%
20	<i>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</i>	Тийм, Сангийн эрсдэлийн удирдлагын журмын дагуу Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлд үнэлгээ хийж, 2022 оны хагас жилийн үйл ажиллагааны тайланд тусгахаар ажиллаж байна.		1	70%
21	<i>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын</i>		Боловсруулсан. Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулаагүй.	2	80%

	<i>хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Боловсруулсан			
ДҮН				5	72.50%
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ					
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	<i>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</i>	Тийм	ТУЗ-ийн төсвийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулдаг	2	100%
23	<i>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.</i>	Тийм	Цалин урамшууллын бодлогын баримт бичгээр зохицуулна.	2	100%
24	<i>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</i>	Сангийн зардал нь ХОМК-ийн шимтгэл байдаг. Үйл ажиллагааны тайланд ХОМК-ийн шимтгэл туссан байдаг.	Гүйцэтгэх удирдлага нь Сангаас цалинждаггүй. Хөрөнгө удирдлагыг хэрэгжүүлдэг ХОМК-оос цалинждаг.	2	100%
ДҮН				6	100%
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	<i>7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</i>	Тийм	Хөрөнгө итгэмжлэн удирдах журам, ХОМК-той хийсэн хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр ХОМК-той хамтран ажилладаг.	2	100%
26	<i>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа</i>	Үгүй. Үйл ажиллагааны онцлогоос хамааран журмаар зохицуулсан тайланг гаргадаг.	Хорооны Хамтын ХОС-ийн үйл ажиллагааны журмын 9 дүгээр зүйлд	2	90%

	<i>ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</i>		заасаны дагуу шаардлагатай зүйлүүдийг тусгасан тайлангаа Хороонд хүргүүлдэг.		
27	<i>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</i>	Тийм	Мандал Ирээдүйн Өсөлт нь өөрийн ХОМК-ийнхоо https://mandalasset.mn/ цахим хуудсаар дамжуулан хөрөнгө оруулагч нартаа мэдээлэл хүргэдэг.	2	90%
28	<i>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</i>	Үгүй.	Сан нь ажилтангүй байдаг. Үйл ажиллагааны онцлогоос хамаараад хэрэгжүүлэх шаардлагагүй зарчим гэж үзэж байна.	2	100%
ДҮН				8	95.00%
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ					
ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	<i>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Боловсруулсан.	Боловсруулсан. Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулахаар ажиллаж байна.	2	80%
30	<i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.</i>	Боловсруулсан.	Боловсруулсан. Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулахаар ажиллаж байна.	2	80%
31	<i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив</i>	Боловсруулсан.	Боловсруулсан. Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулахаар ажиллаж байна.	2	80%

	өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.				
ДҮН				6	80.00%
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Тийм. Үйл ажиллагааны тайландаа тусгаж мэдээллэдэг.	Мандал Ирээдүйн Өсөлт нь өөрийн ХОМК-ийнхоо https://mandalasset.mn/ цахим хуудсаар дамжуулан хөрөнгө оруулагч нартаа мэдээлэл хүргэдэг.	2	100%
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сүвгийг хөгжүүлнэ.	Тийм.	Мандал Ирээдүйн Өсөлт нь өөрийн ХОМК-ийнхоо https://mandalasset.mn/ цахим хуудсаар дамжуулан хөрөнгө оруулагч нартаагаа харилцдаг.	2	100%
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Тийм		2	100%
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Тийм		2	100%
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Тийм	Компанийн дүрэмд сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх заалт байдаг	2	100%
ДҮН				10	100%
НЭГДСЭН ДҮН				66	86.72%